



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 3 сарын 14 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

┌ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ┐
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2,3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 14⁰⁰ цагаас Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 3-р баг, Санжинт хаягт байрлах “Шарын гол” ХК-ийн өөрийн байрны 2 давхрын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - а) Компанийн 2023 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах.
 - б) Компанийн ТУЗ-ийн 2024 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
 - в) Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл.
3. Хурал хуралдуулах тухай, хувьцаа эзэмшигчдэд зарлан мэдэгдэх өдрийг 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2024 оны 04 сарын 03-ны өдөр байхаар тус тус тогтоосугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрөөр тус тус тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудасны загварыг хавсралт 1-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон, танилцах бичиг баримтын жагсаалтыг хавсралт 2-оор, хэвлэл мэдээллээр зарлах хурлын зарыг хавсралт 3-аар, тус тус баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг Гүйцэтгэх захирал /Б.Мэндсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /Л.Эрдэнэжаргал/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Г.Өэлүн/ нарт даалгасугай.
 7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар, ТУЗ-ийн дарга Б.Батбаатарыг томилсугай.
 8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
Үүнд: Комиссын дарга: – ТУЗ-ийн дарга Б.Батбаатар
Комиссын гишүүн: - Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан
ТУЗ-ийн н/б дарга Г.Өэлүн
- Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.
Комиссын дарга: – Худалдаа хангамжийн хэлтсийн дарга - Э.Тодбаяр
Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга - Э.Мөнхцэцэг
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг, хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдуулан хийгдэх ажил, цаг хугацааны графикийг мөрдлөг болгон зохих хууль журмын дагуу хуралдуулахыг комисс /Б.Батбаатар/-д үүрэг болгосугай.



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
03... дугаар тогтоолын Хавсралт №1



“Шарын гол” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчээс

САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр
Регистрийн дугаар
ХЭ-ийн бүртгэлийн дугаар
Эзэмшиж буй хувьцааны төрөл
Тоо

Хурал 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 14:00 цагаас Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 3-р баг, Санжинт хаягт байрлах “Шарын гол” ХК-ийн өөрийн байрны 2 давхрын хурлын танхимд болно.

д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн 2023 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлан	Тогтоол ТУЗ-ийн дүгнэлтийг батлах				
2	Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2024 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах	Тогтоол Зардлын төсвийг батлах				
3	Ногдол ашиг хуваарилаагүй тухай танилцуулга	Мэдээлэл тул санал хураахгүй				

Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр 4 дүгээр сарын 26 болно.

Санал өгсөн хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга

гишүүд:

.....

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

.....

.....

Санал авах хуудсын ашиглах санамж

- Санал өгөх тэмдэглэл \checkmark тэмдэглэнэ.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс болон “Шарын гол” ХК-ийн УБ дахь Төлөөлөгчийн газар дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгч болно.
- Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 99155399, 99007448 утсаар лавлаж болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
..03.. дугаар тогтоолын Хавсралт №2



**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хуралтай холбогдуулан хувьцаа
эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт**

1. “Шарын гол” ХК-ийн санхүүгийн жилийн тайлан
2. Санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлт
3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах тогтоолын төсөл, түүнтэй холбоотой баримт материал



“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн 14 цагаас Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 3-р баг, Санжинт хаягт байрлах “Шарын гол” ХК-ийн өөрийн байрны 2 давхарын хурлын танхимд болох тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Бүртгэлийн өдөр: 2024 оны 4-р сарын 3-ны өдөр

Хуралд хэлэлцэх асуудал

1. Компанийн 2023 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх батлах
2. Компанийн ТУЗ-ийн 2024 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
3. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл.

Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдөр: хурал хуралдах өдөр

Хуралд хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй харьяа брокер диллерийн компаниуд болон Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-17, Зориг сангийн байр 3 тоотод ажлын цагаар /09 цагаас 18 цаг хүртэл/ танилцах буюу дараах утсаар лавлана уу.

Утас: 99155399

Электрон шуудан: oelun@sharyngol.mn

Хурал зохион байгуулах комисс